

ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2014 оны 8-р сарын 13-ны байдлаар*


2014 оны 8-р сарын 13-ны байдлаар хүнсний гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 2.5 хувь, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад 0.1 хувиар буурсан байна.

Махны дундаж үнэ: 2014 оны 8-р сарын 13-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сарынхаас 5.5 хувь, үхрийн ястай махны үнэ 5.9 хувь, үхрийн цул махны үнэ 9.4 хувь, адууны махны үнэ 5.4 хувиар буурч, ямааны махны үнэ 6.3 хувиар буурсан байна.

Өмнөх 7 хоногийнхтой харьцуулбал үхрийн ястай махны үнэ 3.5 хувь, үхрийн цул махны үнэ 1.2 хувь, ямааны махны үнэ 2.4 хувиар буурч, хонины ястай махны үнэ 0.6 хувиар өссөн бол, адууны махны үнэ өөрчлөлтгүй байна.

2014 оны 8-р сарын 13-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 6635 төгрөг, үхрийн /ястай/ мах 7485 төгрөг, үхрийн цул мах 8880 төгрөг, адууны мах 5940 төгрөг, ямааны мах 5810 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).


Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ



Гурилын үнэ: 2014 оны 8-р сарын 13-ны байдлаар өмнөх сарынхаас дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ 0.9 хувь, дээд зэргийн савласан гурилын үнэ 0.8 хувиар буурч, 1-р зэргийн гурилын үнэ 2.0 хувь, 2-р зэргийн гурилын үнэ 7.4 хувиар өссөн байна. Харин өмнөх 7 хоногийнхоос 2-р зэргийн гурилын үнэ 2.4 хувиар буурч, бусад гурилны үнэ өөрчлөлтгүй байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2014 оны 8-р сарын 13-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сарынхаас өөрчлөлтгүй, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад 0.9 хувиар өссөн бол, элсэн чихрийн үнэ өмнөх сарынхаас 2.4 хувиар өсч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна (Зураг2).

Зураг2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2014 оны 8-р сарын 13-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ өөрчлөлтгүй, манжингийн үнэ 17.7 хувь, луувангийн үнэ 18.0 хувь, сонгины үнэ 0.8 хувь, байцааны үнэ 14.3 хувиар буурсан байна.

Өмнөх 7 хоногийнхоос байцааны үнэ 2.9 хувиар өсч, луувангийн үнэ 7.3 хувиар буурчээ.

Сүү, өндөг, ургамлын болон цэцгийн тосны дундаж үнэ: 2014 оны 8-р сарын 13-ны байдлаар өмнөх сарынхаас савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.5 хувь, “Элекстер” /0.5 л/ савласан сүүний үнэ 2.0 хувь, задгай сүүний үнэ 9.1 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхоос савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.2 хувиар өссөн байна.

Ургамлын тосны үнэ өмнөх сарынхаас 0.2 хувиар өссөн бол, өмнөх 7 хоногийнхоос 0.2 хувиар буурсан байна. Өндөгний үнэ өмнөх сарынхаас 5.6 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй, цэцгийн тосны үнэ өмнөх сарынхаас 1.0 хувиар өсч, өмнөх 7 хоногийнхоос 0.2 хувиар буурсан байна.

**ҮСХ-ны Макро эдийн засгийн статистикийн газар
2014 оны 8-р сарын 13**